

МОНГОЛ-ЗӨВЛӨЛТИЙН ХУДАЛДАА: ХӨГЖИЛ, ТӨЛӨВШЛИЙН АСУУДЛУУД (1921-1930 он)

Ц.БАТБАЯР

Академич

ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн

Г.БАТТҮШИГ

Магистр

Эрдэм шинжилгээний ажилтан,

ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн

Монгол улсын эдийн засаг, нийгмийн талаарх 1920-иод оны чухал өөрчлөлт нь МАН, АЗГ-аас боловсруулсан эдийн засгийн үндсэн бодлогын дагуу хэрэгжсэн билээ. 1924 онд Монголын Худалдаа, аж үйлдвэрийн банкийг байгуулж, 1925-1928 онд үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд оруулан, мөн хугацаанд дотоодын гаалийг аажмаар хорогдуулахын хамт гадаадын худалдаачид, газар түрээслэгчдийн орлого болон ангийн үсний экспортоос авах гааль татварыг нэмэгдүүлжээ. 1921 онд байгуулагдсан Харилцан туслалцах хоршоо /Монценкооп/-оос үүсгэвэр авсан Монголын худалдааны байгууллагын эзлэх хувь хэмжээ жилээс жилд өсч байлаа. Энэ бүхэн нь Монголд үндэсний нэгдсэн зах зээл бий болох нөхцлийг алхам алхамаар бүрэлдүүлж байв гэж үзэж болно. Эдгээрт Зөвлөлтийн санхүү, худалдааны байгууллагуудын үүрэг роль, эерэг сөрөг талыг иж бүрнээр нь авч үзэх шаардлагатай байгаа юм. Монгол-Зөвлөлтийн эдийн засаг, худалдааны харилцааг эрх тэгш, харилцан ашигтай хөгжүүлэхийг Монголын Засгийн газар анхаарч байлаа.

Иймд, 1921-1930 оны Монгол-Зөвлөлтийн худалдааг дараах байдлаар үечилж авч үзэв.

Нэг. Монгол-Зөвлөлтийн худалдаа, эдийн засгийн харилцааны эхний үе шат (1921-1924)

МАН-аас боловсруулсан “Эдийн засгийн үндсэн бодлого” хэмээх баримт бичгийг МАН-ын II их хурлаар 1923 оны 8-р сард баталжээ¹. Түүнд үндэсний аж үйлдвэрийг хөгжүүлэх, орчин үеийн зам тээвэр, холбоо харилцаа, данс бүртгэлийн нэгдсэн тогтолцоо бий болгох нь эдийн засгийн хөгжилд нэн чухал хүчин зүйл мөнхийг тэмдэглэв. Худалдааны бодлогыг онцгой анхаарч, харилцан ашигтай байх зарчим дээр аль ч оронтой нийгмийн байгууллыг үл харгалзан худалдаа арилжаа

1 Монгол Ардын Намын Хоёрдугаар их хурал (баримт бичгүүд). УБ., 1974. т. 133-140

хийх, Герман, Англи, Орос, Америк, Хятад, Японтой худалдааны харилцаа хөгжүүлэхээр тусгажээ. Үүний хамт үндэсний банк, мөнгөн тэмдэгт, санхүүгийн тогтолцоог бий болгож, жин хэмжүүр, гааль, татварын үйл ажиллагаанд хатуу хяналт тавихыг цохон заажээ.

Ардын засаг дотоодын зах зээлийг бий болгохын тулд хоршооллын ба энгийн худалдааны хэлбэрийг хөхиүлэн дэмжиж байсан юм. 1921 оны 12 дугаар сард байгуулагдсан Монгол Ардын харилцан туслалцах хоршооны үндсэн зорилт нь үндэсний зах зээлийг эзэмших, хүн амыг өргөн хэрэглээний бараагаар хангах, түүхий эд бэлтгэх, дотоод, гадаад худалдааг эрхлэн хариуцах явдал байв. МАХТХ /Монценкооп/-ны салбар цэгүүд орон нутагт байгуулагдаж өргөжсөн төдийгүй Зөвлөлт, Хятад зэрэг орнуудад өөрийн төлөөлөгчийг ажиллуулах болж, дотоод гадаадын худалдааны яармаг, дуудлагын худалдаанд бараа түүхий эдээ арилжих, худалдах зэргээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байлаа².

Монголын Харилцан туслалцах хоршооны үүсэл 1921-1924 он

Эд хэрэглэгчдийн Харилцан Туслалцах Хоршоо нь 1921 оны 12 дугаар сард Богд хаан, Их дагина болон бусад хүмүүс оролцсон дал гаруй гишүүнтэй 15 мянга орчим төгрөгийн үндсэн хөрөнгөтэйгөөр “Монголын Эд Хэрэглэгчдийн Харилцан туслалцах хоршоо” байгуулагджээ. Мөн Ерөнхий сайд Д.Бодоо, сайд Пунцагдорж, С.Данзан, Д.Сүхбаатар, Магсар хурц нараас гадна яамдын дэд сайд, эрхэлсэн түшмэд, эгэл ард, малчин, лам хувраг, Орос, Хятад зэрэг 113 хүн хоршооны гишүүн болж тэдний хувь нийлүүлсэн хөрөнгө нь 1,300 мексик доллар болжээ.³ МАХТХ-ны үйл ажиллагаа 1921-1922 онд нэлээд цэгцэрч улс орны эдийн засагт гүйцэтгэх үүрэг нь түргэн өсөж байв.

Хоршооны ач холбогдлыг үнэлж Засгийн газраас дэмжлэг үзүүлж байсны дотор 1921, 1922 онд Засгийн газраас тус бүр арван таван мянган лан мөнгө олгож 1922 оноос эхлэн гурван жил дараалан албан татвараас чөлөөлж, улсаас 1924 онд хоёр сая лан мөнгөний зээллэг олгох болсон байна. Төрөөс хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд монголын эд хэрэглэгчдийн хоршоо нь бэхжиж, 1924 он гэхэд хот, хөдөөгийн нийт хорь гаруй салбартай болж өргөжсөн байна.

Тухайлбал, 1923 онд МАХТХ улсын нийт барааны эргэлтэд 4 хүрэхгүй хувь эзэлж байсан бол 1925 онд 24.9% болж, 1926 онд МАХТХ дотооддоо 26%, Бээжин, Тяньжин, Москва, Дээд-Үдэд салбартай болж, бэлтгэсэн ноос түүхий эд ангийн үсээ экспортлох, янз бүрийн бараа бүтээгдэхүүнийг импортлох ажлыг хариуцаж байв. Мөн худалдаанаас гадна ноос угаах газар 14, өлөн гэдэсний 9 заводтой болж орон нутгаар явж өргөн хэрэгцээний зүйл, худалдан борлуулах ба түүхий эд, ангийн үс, эмийн ургамал, бугын эвэр цуглуулж байлаа.

2 МАХН-ын түүхэн замнал. УБ., 1995, т. 32-33

3 Монголын түүх (1911-2017). Ред.О.Батсайхан. УБ., 2018, т. 225

1925 оны Харилцан Туслалцах Хоршооны тайлангаас үзвэл Монгол ардын Харилцан Туслалцах Хоршооны 1924 онд худалдаанаас олсон цэвэр ашиг 533 876 янчаан 19 мөнгө болсон байна. Үүнд Сангийн яамнаас хамт худалдаалахаар тус хоршооны гүйлгээнд оруулсан 1 сая лан бөгөөд 143 8571 төгрөг нэг бүрд 20 мөнгөөр ноогдох ашиг 285 714 төгрөг 20 мөнгө болно.

Мөн он (1924 он)-ы таван сарын шинийн нэгэн хүртэл хувь нийлүүлэн оруулсан гишүүдийн хувийн 127 069 төгрөг 03 мөнгө, тус хоршооны үндсэн хөрөнгө 33 512 төгрөг 70 мөнгө бэлтгэл хөрөнгө 35 378 төгрөг 27 мөнгө, тусгай хөрөнгө 37 200 төгрөг 36 мөнгө, эдгээр тус хоршооны бүх хөрөнгө 233 160 төгрөг 26 мөнгө бас тус хоршоо зээлсэн ба хадгалуулсан 450 654 төгрөг 10 мөнгөний хамт бүгд нийлээд 683 844 төгрөг 36 мөнгөнд төгрөг нэг бүрд 20 мөнгөөр ноогдох ашиг буюу Хоршооноос 1924 онд олсон цэвэр ашиг 136 768 төгрөг 87 мөнгө байв⁴.

МАХТХ улс ардын аж ахуйд хэрэгцээтэй машин механизмыг ч гаднаас оруулж ирж байв. Жишээлбэл: МАХТХ 1924 оны 5 дугаар сарын 15-нд Германы “Герман-Азийн” компаниас Харбинаар дамжуулан 700 пүүд улаан буудайг цэвэрлэх, бутлах хүчин чадалтай автомат тээрэм, эд ангийн хамт нийт 9914 ам. доллараар худалдан авсан баримт 1924 оны Хоршооны тайланд хавсаргажээ⁵.

Монгол-Зөвлөлтийн худалдааны гэрээ 1923 он

1922 оны 6-р сард Зөвлөлт Орост суугаа Монголын бүрэн эрхт төлөөлөгч худалдаа, банк, шуудан-цахилгаан холбооны асуудлаар хоёр орны хооронд гэрээ хэлэлцээр байгуулах саналыг Зөвлөлтийн талд тавьжээ. Үүний дагуу АЗГ худалдааны хэлэлцээр хийх төлөөлөгчөө 1923 оны 5-р сард Москвад илгээсэн ба уг гэрээнд 1923 оны дунд үед Нийслэл Хүрээнд гарын үсэг зурсан⁶ хэмээн түүхийн судалгааны бүтээлд өгүүлжээ.

ШУА-ийн ТУЗХ-ийн баримтын санд Монгол-Зөвлөлтийн худалдааны хэлэлцээрийн төсөл орос хэлээр хадгалагдаж байна. Уг төсөл “Проект Торгового соглашения между НП Монголии и Пр-вом РСФСР” нэртэй бөгөөд толгой дээр нь “Проект НКВД исправленный и дополненный Б.Шумяцким” гэж бичсэн байдаг. Төсөл нийт 22 зүйлтэй бөгөөд төгсгөлд нь Б.Шумяцкий, 1922. 2/II гэсэн огноо тавьж, 3-р зүйлд хоёр улсын иргэдэд хоёр орны газар нутагт худалдаа арилжаа эрхлэхэд харилцан нэн таатай нөхцлийг бүрдүүлнэ гэж заасан байна. 5-р зүйлд гааль, татвар бусад хураамжийн хувьд ч хоёр орны иргэд нэн таатай нөхцлийг эдэлнэ гэж заасан байна. 9-р зүйлд монголын зах зээлийг империалист орнуудын капиталаас хамгаалахын тулд РСФСР-ын зээл, хоршооллын байгууллагуудад давуу эрх олгохоор заасан байна⁷.

4 МУУТА. УТНОНББА. Х-17, Д-1, ХН-4, хуудас 37-41

5 МУУТА. УТНОНББА. Х.17, д.1, ХН-3

6 Монгол Зөвлөлтийн харилцааны түүх (1921-1978). УХГ, УБ., 1981. Т. 66-67

7 ШУА-ийн ТУЗХ. ССБМТ. Х-5. Д-1. ХН-142

“Монголын тухай БХКН-ын баримт бичиг 1920-1932” баримтын эмхэтгэлд ЗСБНХОУ-ын Ардын комиссар нарын Зөвлөлийн 1922 оны 6-р сарын 27, 8-р сарын 1-ний хуралдааны протоколд Монгол-Зөвлөлтийн худалдааны хэлэлцээрт оруулах засварын тухай, ялангуяа банкны тухай нэмэлт зүйл оруулахаар хэлэлцжээ. Эдгээр протоколоос үзвэл Худалдааны хэлэлцээрт Москва хотноо 1922 оны 6-р сараас 8-р сарын хооронд гарын үсэг зурсан байх магадлалтай бөгөөд “туйлын нууц” байдлаар зурсан учир гарын үсэг зурсан эх нь манай ГХТА-т байхгүй байна.

1921-1924 онуудад Зөвлөлтийн худалдааны байгууллагууд, “Центросоюз”, “Шерсть”, “Сибгосторг”, “Дальгосторг”, Чикойскийн арьс ширний завод зэрэг төрийн болон хоршооллын байгууллагууд Монголд үйл ажиллагаа явуулж байв. Зөвлөлтийн байгууллагууд гаалийн хөнгөлөлт үзүүлэх, монголын түүхий эдэд хөдлөшгүй хатуу үнэ тогтоох, төмөр замын хөлсийг хямдруулах зэрэг арга хэмжээ авч байсан боловч эдгээр жилүүдэд Хятад, барууны орны пүүсүүд Монголын зах зээлд давамгайлсан хэвээр байв.

Монголд 1921 оноос өмнө ажиллаж байсан, зах зээлээ сайн мэдэх “Центросоюз” нийгэмлэг Монголын зах зээл дээр амжилттай ажиллаж, ялангуяа мал, мах, ангийн арьс үс худалдан авч Сибирь, Зөвлөлт Оросын европын хэсэгт нийлүүлж байв. “Центросоюз”-ын шугамаар:

1921 он: 31000 үхэр, 5000 хонь

1922 он: 22000 хонь, үхэр, 158 мян. ширхэг арьс шир, ангийн үс

1923 он: 21000 хонь, үхэр, 328 мян. ширхэг арьс шир, ангийн үс бэлтгэжээ⁸. / Дьяченко Н.В.Барнаул. 2005/

Монголын нийт бараа гүйлгээ 1922 онд 32,5 сая рубль, 1924 онд 37,5 сая рубль байв. ЗХУ-ын хувийн жин 1924 онд нийт 5 сая рубль буюу Монголын нийт бараа эргэлтийн 14 орчим хувийг эзэлж байлаа. Монголоос гадаадад гаргаж байсан түүхий эд, мал махны дотор ЗХУ-д үхрийн 40%, хонины 6%, ноосны 13%, өөх тосны 73%, өлөн гэдэсний 14% гаргаж байжээ. ЗХУ-аас сав суулга, ширэн эдлэл, нефть, гурил, ётон худалдаж авч байснаас гурилын хэрэгцээний 87%-ийг, ширэн эдлэлийн 43%, нефтийн 50% авч байв⁹.

Улсын анхдугаар их хурал: Сангийн яамны илтгэл 1924 он

АЗГ-аас 1923 оны эхээр 37 зүйл бүхий гаалийн дүрэм батлан гаргаж мөрдүүлжээ. Сангийн сайд Ө.Доржоос Улсын анхдугаар их хуралд тавьсан илтгэлд: “гадаадаас авчирсан боловсорсон эд бараанаас 6%, гадаадад явуулах мал ба түүхий эдээс гадаад дотоодын гааль тус бүр 6% бодож хураахаар болсон” нь улсын санг арвижуулах зорилгоор авч хэрэгжүүлжээ. Сангийн яамны илтгэлд

8 Н.В.Дьяченко. Сибирь в системе советско-Монгольских торгово-экономических отношений в 1917-1939 гг. Барнаул. 2005 г.

9 М.В.Мешеряков. ЗХУ ба БНМАУ-ын эдийн засгийн хамтын ажиллагааны тойм. УБ., 1959. т. 62-64

Нийслэл Хүрээнд үйл ажиллагаа явуулж байсан гадаадын пүүс, компаниудын тоо, тэднээс хураасан гаалийн дүнг 1922-1924 оны байдлаар дурдсан байна. Үүнд:

Аль орны пүүс	1922 онд гаалийн татвар хураалгасан пүүсийн тоо	1923 онд гаалийн татвар хураалгасан пүүсийн тоо	1924 онд гаалийн татвар хураалгасан пүүсийн тоо
Оросын пүүс	20	57	166
Америк, Англи, Германы пүүс	5	26	62
Хятад пүүс	163	476	818
Хятадын хөдөө пүүс	700	1077	625
	41347 лан	108318 лан	121127 лан

ЗСБНХОУ-ын онц эрхэд хамаарах Худалдаа аж үйлдвэрийн банк байгуулах асуудлыг ЗХУ-ын эрх бүхий байгууллагууд 1922 оноос эхлэн хэлэлцэж, БХКБН-ын УТТ –ноос 1924 онд зохих шийдвэр гарсны дагуу 1924 оны 6 дугаар сард Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн тус банкыг Нийслэл Хүрээнд нээсэн байна. Монголын мөнгөний зах зээлийг Хятадын валютын хараат байдлаас чөлөөлөх зорилгоор Монголын санхүүгийн ажлыг өөрчлөн зохион байгуулах А.О. Альский тэргүүтэй санхүүгийн Комиссыг 1925 оны 1-р сард Монголд томилон ажиллуулж, Д.Д. Михельманыг Монгол банкны дарга бөгөөд санхүүгийн зөвлөхөөр томилжээ¹⁰.

АЗГ-ын шийдвэрээр 1925.12.09-нд үндэсний мөнгөн тэмдэгтийг гаргаж гүйлгээнд оруулснаар санхүүгийн нэгдсэн системийг бэхжүүлэх, зах зээлээс бусад валютыг шахаж гаргах хөшүүрэг болов. 1925-1928 он гэхэд үндэсний мөнгөн тэмдэгт төгрөг, хятадын доллар хоёр төлбөрийн гол хэрэгсэл болж, 1929 оноос зөвхөн төгрөгөөр бүх гүйлгээг хийх болжээ.

БХКБН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо 1923 оны 8 сарын 2-нд Монголд суух Бүрэн эрхт төлөөлөгчөөр А.Н. Васильевыг томилж, түүнд мөн анхны Худалдааны төлөөлөгчийн албыг хавсруулсан байна. 1925 оны 7-р сард Бүрэн эрхт төлөөлөгчөөр томилогдсон П.М.Никифоров Г.В. Чичеринтай уулзсан уулзалтын тэмдэглэлдээ: “Монголыг эдийн засгийн байгууллаар Зөвлөлт хэлбэрт ойртуулах” зорилт тавиад, “Монголд манай худалдааны хоёр хүчирхэг байгууллага: “Сибгосторг”, “Ноос” нийгэмлэг хоёр ажиллаж байна. Тэдний ажлыг бүх талаар дэмжих” хэмээн бичиж байв¹¹.

10 Монголын тухай БХКБН-ын баримт бичигт (1920-1932), УБ., 2002, т. 174-178

11 ХХ зууны 20-иод оны тэмдэглэлүүд. Баримтын эмхэтгэл. Эмхэтгэсэн. Д.Өлзийбаатар. УБ., 2007. т. 12-13

Амар, Жадамба нар 1926 оны 1 дүгээр сард Москвад очсон нь

Ерөнхий сайдын орлогч бөгөөд Аж ахуйн явдлын яамны сайд А.Амар, Засгийн газрын эрхлэх товчооны гишүүн Н.Жадамба нар 1926 оны 1-р сард Москва хотод хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааны талаар хэлэлцэхдээ Гадаад хэргийн Ардын комиссар Г.В.Чичеринд хоёр улсын худалдаа, бусад салбарт гарч буй бэрхшээл, түүнийг гэтлэн давах арга замын тухай захидал бичиж, Г.В.Чичеринээс хариу захидлыг авч иржээ. Амар нарын захидалд: хоёр орны худалдаа, Монголд аж үйлдвэрийг хөгжүүлэх, тээх нэвтрүүлэх явдал, банк санхүү зэрэг салбарт гарч буй үл нийлэлцэх зүйлүүдийг ил тодоор бичиж, тэдгээрийг хэрхэн засаж сайжруулах талаар санал бодлоо илэрхийлжээ. Үүнд, худалдааны салбарт:

- Зөвлөлтийн худалдааны байгууллагууд монголын түүхий эдийн үнийг элдэв арга хэрэглэн бууруулах, үнэ буурах улирлын үед хааж боогдуулах, гадаадаас нэвтрүүлэх барааг хэтэрхий ихээр буюу хэтэрхий хомсоор оруулах,
- Зөвлөлтийн байгууллагууд зарим бараанд онц эрх эдэлж буйгаа ашиглан чөлөөтэй өрсөлдөхийг боож, үнийг бага болгох явдалд саад хийх,
- Холбоот улсад Монгол хоршоог саадгүй худалдаа эрхлэх явдлыг сахин хамгаалах,
- Холбоот улсаар нааш, цааш нэвтрүүлэх, мөн Холбоот улсын хязгаарт оруулсан эд барааг шууд нэвтрүүлэх эрхийг Монгол улсад олгох,
- Зөвлөлтийн байгууллагууд хятадын жижиг шунахай худалдаачдыг ашиглан хэрэглэх явдлыг зогсоох,
- Холбоот улсад худалдаалах Монголын газруудад, мөн Монголын газрын онц байдлыг дагуулж худалдааны хэрэгт удаан хугацааны тусгай хөрөнгө зээлүүлэх гэсэн тодорхой саналуудыг хүргүүлж байжээ¹².

Монгол-Зөвлөлтийн худалдаа, эдийн засгийн харилцааны хоёр дахь шат (1925-1930)

“Ноос” нийгэмлэг Монголын зах зээл дээр ажиллаж, 1923 онд 700 тонн, 1925 онд 1000 тонн, 1927 онд 5000 тонн ноос бэлтгэжээ. 1924-1928 онуудад Зөвлөлтийн байгууллагууд Монголын хонь ба тэмээний ноосны зах зээл дээр идэвхитэй ажиллаж, зах зээлийн 50 орчим хувийг эзлэн авчээ. “Ноос” нийгэмлэг “Кауфман ба түншүүд” гадаадын томоохон пүүсийн Монгол дахь сүлжээг худалдан авчээ. Мөн МАХТХ 1925 онд Английн “Вильсон” компанитай ноос ноолуур худалдаалах талаар гэрээ байгуулсныг эсэргүүцэж, БХКБН-ын УТТ-ны 1926.04.22-ний хурлаар “Монценкоопын Вильсон компанитай байгуулсан гэрээ”-ний тухай асуудлыг хэлэлцүүлж байв.

12 “Үнэн” сонин, 1989 оны 11 сарын 29. № 285(17502)

1924-1928 оны Ноос бэлтгэл

Он	1924	1925	1926	1927	1928
Монголын Хоршоо	1500 т.	2172 т.	2758 т.	2701 т.	4705 т.
Зөвлөлтийн байгууллагууд	1219	2182	4338	5350	5770
Англи-Америкийн	1680	1465	733	400	-
Хятадын ПҮҮСҮҮД	4051	3331	1571	1459	1225
Нийт	8450	9150	9400	10000	11700

Эх сурвалж: М.В.Мешеряков. ЗХУ ба БНМАУ-ын эдийн засгийн хамтын ажиллагааны тойм. УБ., 1959. т.68-69

Монгол дахь эдийн засгийн ажлын тухай БХКБН-ын УТТ-ны Монголын Комиссын хуралдааны 1926.05.15-ны протоколоос үзвэл А.Амар нарын Чичеринд бичсэн захидалд тусгагдсан асуудлуудыг цэгцлэх талаар тодорхой арга хэмжээ авсан нь харагдаж байна. Үүнд: барааны нэр төрөл нь монголын эд хэрэглэгчдэд яг тохирсон бөгөөд зөвлөлтийн бараа таваар үнэ өртгийн байдлаар гадаадынхантай өрсөлдөж чадахуйц, тийм таваарын нөөцөөр хангаж байх, Монгол хэрэгтэй бөс бараа /даалимба, цууямбуу/ яравчлан үйлдвэрлэх эрс арга хэмжээ авах, хоорондоо өрсөлдөх, эсвэл Монценкооптой өрсөлдөх явдлыг зогсоох, Монценкооп болон Монголд ажиллаж байгаа зөвлөлтийн байгууллагуудын бүрэлдэхүүн бүхий холимог нийгэмлэг байгуулах гэж тогтоожээ¹³.

Монголд үйл ажиллагаа эрхэлж, зарим үед хоорондоо өрсөлдөж байсан Зөвлөлтийн худалдааны байгууллагуудыг цэгцлэх үүднээс Зөвлөлт Засгийн газраас 1,5 сая рублийн дүрмийн сантай “Стормонг” хувь нийлүүлсэн нийгэмлэгийг байгуулж 1927 оны 6-р сарын 1-нээс эхлэн Монголын нутагт Зөвлөлтөд үйлдвэрлэсэн бараа таваар худалдан борлуулах, түүхий эд бэлтгэх ажлыг явуулах болжээ. Үүний дагуу “Ноос” болон бусад зөвлөлтийн бүх байгууллагууд ажлаа зогсоосон байна.

БХКБН-ын Төв Хорооны Улс төрийн товчоо 1927 оны 7 сарын 14-нд Монголтой эдийн засаг, худалдааны хэлхээ холбоогоо бэхжүүлэх тухай хэлэлцээд зарим эрс арга хэмжээ авчээ. Үүнд:

- БНМАУ болон ЗСБНХУ-ын хооронд худалдааны гэрээ байгуулахаар хэлэлцээ хийж эхлэх,
- Монголд худалдах зөвлөлтийн барааны үнийг чанар нь тохирох гадаад гаралтай барааны үнээс илүүгүй байлгах,

¹³ Монголын тухай БХКБН-ын баримт бичигт (1920-1932). Улаанбаатар, 2002. т. 214-217

- Монголын зах зээлийн хэрэгцээг зөвлөлтийн аж үйлдвэрийн төлөвлөгөөнд оруулж, барааны чанар, нэр төрөл зэргийн талаар Монголын зах зээлийн бүхий л онцлогийг харгалзан бараа үйлдвэрлэх
- Монценкооп (4000000 рубль хүртэл) болон Стормонг-д зээл олгох явдлыг нэмэгдүүлэх зэрэг гэжээ¹⁴.

1929 оны 6 дугаар сарын 27-нд “БНМАУ, ЗСБНХУ-ын хоорондын харилцааны үндсэн зарчмуудын тухай” хэлэлцээр байгуулагдав. Хэлэлцээрт Монголын талаас Ерөнхий сайдын орлогч бөгөөд Аж ахуйн яамны сайд Ж.Дамдинсүрэн, ГЯЯ-ны сайд Г.Гүрсэд, УБХ-ын гишүүн П.Гэндэн нар, зөвлөлтийн талаас бүрэн эрх барих төлөөлөгч А.Я.Охтин, худалдааны төлөөлөгч Ботвиник, ЭСЯ-ны 1 дүгээр нарийн бичгийн дарга А.Климов нар гарын үсэг зуржээ. Өнгөцхөн харвал аж ахуйн чанартай мэт боловч цаагуураа улс төр-эдийн засгийн гүн гүнзгий утга агуулгатай бөгөөд үүгээр монголын тал эдийн засгийн гадаад харилцааны эрхээ зөвлөлтийн талд шилжүүлсэн байна гэж судлаач Р.Янжмаа бичжээ¹⁵.

Монгол-Зөвлөлтийн харилцааны үндсэн зарчмуудыг тогтоосон хэлэлцээрт: “СССР нь Монголыг, Монгол нь СССР-ыг ийнхүү онцоор үзсэн лүгээ адил бусад гадаад улсыг үзэх бол энэ нь хоёр этгээдийн уул бодлого зорилго лугаа үл нийцэх тул аливаа гадаад улсууд ба тэрхүү улсуудын харьяат нарт тийнхүү онцоор үзэх явдлыг үл дэлгэрүүлэхийг хоёр этгээдээс батална” гэж “Онц дотночлон үзэх тухай” 7 дугаар бүлэгт заажээ. ЗХУ монголын малын ба бусад аж ахуйгаас гарах бөгөөд гадаадын дэлгүүрт худалдах түүхий эд зүйлийг худалдан авахыг хичээнэ. Мөн Монгол Ард Улсын олон ардын чухал хэрэглэх ба малын ажил тариалан хийгээд аж үйлдвэрийн хэргийг боловсноор хөгжүүлэх явдалд чухал хэрэглэх зүйлүүдийг бэлтгэх явдалд туслахын учир СССР-ийн Засгийн газраас Монголын ард аж ахуйд хэрэглэх зүйлүүдийг бэлтгэж өгөхийг зөвшөөрнө. Хэрэв уул хэрэгцээт барааны зарим нэг хэсэг нь ЗХУ-д байхгүй байвал ЗХУ захиалга ёсоор өөр орноос авч өгөх үүргийг хүлээжээ. ЗХУ урамшил болгож дэлхий нийтийн үнэн дээр 5 хувийн нэмэгдэл бүхий үнийг монголын түүхий эдэд тогтоохыг зөвшөөрчээ.



Мөн уг хэлэлцээрт Монголын аж ахуйн газрууд нь Холбоот улсын эд барааг урьдал болгож үлэмжхэнээр Монголд оруулахыг чухалчлан оролдож, Холбоот улсын зохих газруудаас мал ажлын түүхий эдийг худалдан авахад дөхөм болгохыг хичээнэ гэжээ¹⁶.

14 Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичгийн (1920-1932). УБ., 2002. т. 233-234

15 Г.Яанжмаа. Монгол улсын уламжлалт алба үүсч хөгжсөн түүхээс. <<Дорно-Өрнө>>, 1996. №2. т. 20

16 МУ-ын ГХТА, Х-199, Д-1, ХН-02/28131

1929 оны хэлэлцээний нүүр:



Эх сурвалж: МУ-ын ГХТА. Х-199, Д-1, ХН-02/28131

1929 оны хэлэлцээр, түүний үр дүн

Энэхүү хэлэлцээрийн үр дүн нэн даруй гарч эхлэв. Хэлэлцээрийн өмнөх жил 1928 онд ЗХУ-аас БНМАУ-ын экспортод эзлэх хувийн жин 57,8 %, импортод эзлэх хувийн жин 23,8% байсан бол 1930 онд дээрх үзүүлэлтүүд 90,2% болон 74,9% болон эрс нэмэгдсэн байна. СССР ба БНМАУ-ын худалдааны эргэлт 1927-

28 онд 68,9 сая рубль байсан бол 1930 онд 130,9 сая рубль болж өсчээ. 1930 оныг 1924 онтой харьцуулбал БНМАУ-аас СССР-т нийлүүлсэн амьд мал 7 дахин, ноос 5 дахин, арьс шир 4 дахин нэмэгдсэн байна. 1925-1930 оны хооронд Монгол-Зөвлөлтийн худалдааны эргэлтийг авч үзвэл /сая рубль/:

ОН	ЗХУ-аас авсан бараа	ЗХУ-д импортоор нийлүүлсэн бараа	Нийт эргэлт
1924/25 он	9,6	12,5	22,1 сая рубль
1925/26 он	12,8	13,0	25,8 сая р.
1926/27 он	16,1	26,5	42,6 сая р.
1927/28 он	26,7	42,2	68,9 сая р.
1929 он	35,1	53,2	88,3 сая р.
1930	62,1	68,8	130,9 сая рубль

Эх сурвалж: М.В.Мешеряков. ЗХУ ба БНМАУ-ын эдийн засгийн хамтын ажиллагааны тойм. УБ., 1959. т.74-75

Дүгнэлт

1921-1930 онд Монголд үндэсний нэгдсэн зах зээл бий болох нөхцлийг алхам алхамаар бүрэлдүүлж байв гэж үзэж болно. Энэ бүхэнд Зөвлөлтийн санхүү, худалдааны байгууллагуудын үүрэг роль, эерэг сөрөг талыг иж бүрнээр нь авч үзэх шаардлагатай байгаа юм. Монгол-Зөвлөлтийн эдийн засаг, худалдааны харилцааг эрх тэгш, харилцан ашигтай хөгжүүлэхийг Монголын Засгийн газар анхаарч байлаа.

Монгол-Зөвлөлтийн худалдааг 1921-1924, 1925-1930 он гэж хоёр үед хуваан авч үзэв. Эхний үед Монголын зах зээлийг сайн мэдэх Сибирийн “Центросоюз” гол үүрэг гүйцэтгэж, амьд мал, малын арьс шир, ангийн үс худалдан авч Сибирь төдийгүй, Европын хэсэгт нийлүүлж байв. 1923 оноос эхлэн “Шерсть”, “Сибгосторг”, “Дальгосторг”, Чикойскийн арьс ширний завод зэрэг төрийн болон хоршооллын байгууллагууд Монголд үйл ажиллагаа явуулж байв.

Зөвлөлтийн байгууллагууд хоорондоо өрсөлдөж, хятадын жижиг худалдаачдыг ашиглан, монголчуудын түүхий эдийг хямдаар авах, зөвлөлтийн барааг хиймэл хомсдол үүсгэн өндөр үнээр зарах зэрэг зохисгүй үзэгдэл гарах болсон тул 1927 оноос эхлэн “Стормонг” хэмээх нэгдсэн байгууллага байгуулж түүгээр дамжуулж бүх худалдааг хийх болов.

АЗГ, ялангуяа Аж ахуйн яамны сайд А.Амар нар Монгол-Зөвлөлтийн худалдаанд гарч буй зохисгүй зүйлийг шүүмжилж, 1926 оны эхээр ЗХУ-д айлчлал хийхдээ Зөвлөлтийн төрийн удирдлагад албан захидал хүргүүлж, эрх тэгш, харилцан ашигтай худалдаа хийхийг сануулж байсан нь худалдааны салбар дахь хамтын ажиллагаанд ахиц гарсан юм.

ЗХУ-ын Засгийн газар Монголтой эдийн засаг, худалдааны харилцааг бэхжүүлэх үүднээс эрс шийдвэртэй хэд хэдэн арга хэмжээг 1927-1929 онд авсны нэг нь 1929 оны 6-р сард байгуулсан “БНМАУ, ЗСБНХУ-ын хоорондын харилцааны үндсэн зарчмуудын тухай” хэлэлцээр байлаа. Ингэснээр гадаад худалдаанд онц эрхийг тогтоож, гадаадын пүүс компаниудыг шахан гаргасан байна.